



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“ОРХОН АЗЗА” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу
УАГ-ын Санхүүгийн аудитын газрын
захирал бөгөөд тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас:261663

Түншлэл, аж ахуй нэгж байгууллага
Цахим хаяг: www.audit.mn


Монгол Улсын УАГ
Монгол Улс Чингэлтэй дүүрэг бага тойруу
Засгийн газрын IV байр
Цахим хуудас: www.audit.mn



ГҮЙЦЭТГЭСЭН
“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК
Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг 4-р хороо
Цэцээ гүн 206 тоот
Утас: 70001981, 99096584
Зөвлөх үйлчилгээ 1900-1981

Аудитын тайлан

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан
- Хавсралт 4: Зорилтод түвшин



Агуулга

| | | |
|-----|--|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 3 |
| 2 | Аудитын тайлан | 4 |
| 2.1 | Оршил | 4 |
| 3. | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага..... | 4 |
| 4. | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 5. | Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 5 |
| 6. | Материаллаг байдал | 6 |
| 7. | Дотоод хяналт | 6 |
| 8. | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 6 |
| 9. | Олж тогтоосон эрсдэлүүд, түүний үр дагавар..... | 6 |
| 10. | Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар | 7 |
| 11. | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл..... | 7 |
| 13. | Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар | 8 |
| 15. | Санхүүгийн тайланд аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл | 8 |
| 16. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 9 |
| 17. | зөрчилгүй санал дүгнэлт | 9 |
| 18. | Менежментийн захидал | 11 |

1 Аудтын гэрчилгээ

“ОРХОН АЗЗА” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.БАТБОЛД ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Орхон АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Орхон АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон АОУС-д нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Орхон АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Орхон АЗЗА” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй. Аудитын байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

"Орхон АЗЗА" ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг "Орхон АЗЗА" ТӨХК-ийн ТУЗ, гүйцэтгэх захирал Х.Батболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, зорилтод түвшингийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг тодорхойлсон болно.

3. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Орхон АЗЗА" ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд/САГ-2018/133/СТА/ТӨХК санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон улсын стандарт /АОУС/, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

"Орхон АЗЗА" ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

"Орхон АЗЗА" ТӨХК-ийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-тай нийцүүлж материаллаг алдаагүй нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, зорилтод түвшингийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-наас 2018 оны 03 дугаар сарын 15-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж "Орхон АЗЗА" ТӨХК-ийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн "Си Эс Ай Аудит" ХХК-ийн партнер М.Сэвжидмаа хариуцаж аудитын баг санхүүгийн тайлангийн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг хэрэгжүүлэв.

4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу тус компанийн гүйцэтгэх захирал өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж явуулж байна.

"Орхон АЗЗА" ТӨХК нь төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан "Зам засвар, арчлалтын гэрээ"-ний дагуу улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг Орхон аймгийн хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж ажиллаж байна.

"Орхон АЗЗА"ТӨХК нь авто зам засвар, арчлалтын үйл ажиллагааг гүйцэтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан авто замын урт, тэдгээрийн дагуу байрлах, шугаман албадан байршил, засвар арчлалтын нэгж, норм норматив, төсвийн норм, үнэлгээ болон түрээсийн тоног төхөөрөмжийн машин цагийн норм үнэлгээг мөрдөж ажиллаж байна.

Тайлант онд Авто замын тухай хууль өөрчлөгдсөн бусад хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

5. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын Олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар "Орхон АЗЗА" ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна тус байгууллагын удирдлагаас тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансыг түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

"Орхон АЗЗА" ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

"Орхон АЗЗА" ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн MACS програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2013 онд хийсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого мөрдөж байгаа боловч Сангийн сайдын 249 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар", "Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт"-ыг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 тоот тушаалыг хүчингүй болгосон тул энэ өөрчлөлтийг хийгээгүй байна.

6. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт /АОУС/ 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд орлого, зардал, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгөөр материаллаг байдлын суурь үзүүлэлтийг тооцон харьцуулалт хийж тухайн байгууллагын санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын хоёр хувиар тооцохоор төлөвлөсөн болно.

"Орхон АЗЗА" ТӨХК-ийн төлөвлөлтийн үе шатанд материаллаг түвшинг 2016 оны 1,031.9 сая төгрөгийн нийт зардлаас хоёр хувь 20.6 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд 2017 оны нийт зардал 1,121.9 сая төгрөг бөгөөд түүний хоёр хувь 22.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа. /ТАБ-СТА-В-1/

7. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. "Орхон АЗЗА" ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт дунд байна. ТӨБЗГ-аас 2017 онд 2015-2016 оны санхүү, үйл ажиллагаанд шалгалт хийгдсэн байна.

8. ОРЛОГО, ЗАРДЛЫН ТАЛААР

"Орхон АЗЗА" ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн зорилтод түвшинг ТӨБЗГ-ын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор баталсан.

2017 онд нийт орлогын төлөвлөгөө 1,169.8 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 1,146.6 сая төгрөгийн орлогын гүйцэтгэлтэй ажиллаж 23.2 сая төгрөгөөр давж биелсэн нийт зардал 1,143.3 сая төгрөг батлагдсанаас 1,121.9 сая төгрөгийн зардал гаргаж 24.6 сая төгрөгийн ашигтай ажилсан байна.

9. Шилэн дансны мэдээлэл

"Орхон АЗЗА" ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн <http://shilehdans.gov.mn/> сайтад батлагдсан маягт, хавсралтуудын дагуу төсөв, гүйцэтгэл худалдан авах ажиллагаа, гаргасан гүйлгээ болон санхүүгийн тайлан тэнцэлийн мэдээллийг сар бүр байршуулсан байна.

10. Олж тогтоосон эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 19 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

11. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

2016 оны санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 7.2 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн үлдэгдэл 9.1 сая төгрөгөөр тус, тус илүү илэрхийлэгдсэн.

12. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

“Орхон АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрснийг доорх байдлаар шийдвэрлэсэн болно. Үүнд:

1. Санхүүгийн тайланд Улсын комисст хүлээлгэж өгөөгүй орон нутгийн болон гэрээтэй ажлаас үлдсэн замын ажлын санхүүжилт 235.2 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т “нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: гэсэн заалтын 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага...” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Цагаан чулуут багийн зам засварын санхүүжилтийн дутуу 22.5 сая төгрөг
 2. Яргуйт багийн зам засварын санхүүжилтийн дутуу 22.1 сая төгрөг
 3. Даваат багийн зам засварын санхүүжилтийн дутуу 30.6 сая төгрөг
 4. “Карбин электрик интернэшнл” ХХК-иас авах зам засварын санхүүжилтийн дутуу 160.0 сая төгрөгийн авлагыг тус тус санхүүгийн тайланд залруулав.
2. 2016 оны ТУЗ-ын гишүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг тайлагнаагүй 4.2 сая төгрөгийг нөхөж залруулахдаа тухайн тайлант жилийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар тайлагнаж тайлант жилийн зардлыг өсгөсөн нь Сангийн сайдын 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн “Нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулах”, 15.2. “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна”.. гэсэн заалтыг зөрчсөн

Шийдвэрлэсэн нь

- 2016 оны нийгмийн шимтгэл 4.2 сая төгрөгийг тухайн тайлант жилд зардлаар бүртгэж зардал өсгөснийг хуримтлагдсан үр дүнд залруулга хийж ААНОАТ-ыг нөхөж тооцох.
3. Тайлант онд 2015 оны ногдол ашиг болох 1.8 сая төгрөгийг олгохдоо санхүүгийн зардлаар бүртгэж ашиг бууруулсан.

Шийдвэрлэсэн нь

Ногдол ашгийг хуваарилаж олгохдоо хуримтлагдсан ашиг, ногдол ашгийн өглөг гэсэн дансанд бүртгэлийн бичилт хийж, олгох ногдол ашгаас 10 хувийн татвар төлөхөөр тооцох мөн санхүүгийн тайланд буруу бичилт хийснийг залруулах.

4. ТӨБЗГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А/-5/3481 тушаалаар 15.2 сая төгрөгийн 10 төрлийн компьютер дагалдах хэрэгсэлийн хамт акталсан байна. Үүнд: 2014 онд ашиглалтанд орсон, 4 жил ашиглах хугацаатай, 1.9 сая төгрөгийн нэг бүрийн үнэтэй нийт 7.6 сая төгрөгийн 4 notebook, Epson L555 принтер 0.4 сая төгрөг, бүгд 8.0 сая төгрөгийн хөрөнгийг ашиглах хугацаа дуусаагүй байхад акталсан боловч албан хэрэгцээнд ашиглаж байна.

Шийдвэрлэсэн нь

Ашиглаж байгаа ашиглалтын хугацаа дуусаагүй 8.0 сая төгрөгийн өртөгтэй компьютер дагалдах хэрэгсэлийг орлогод авах.

5. 2016 оны санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 7.2 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн үлдэгдэл 9.1 сая төгрөгөөр тус, тус илүү илэрхийлэгдсэн тухайн үед залруулга хийгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь

Үндсэн хөрөнгө, хуримтлагдсан элэгдлийн 2016 онд үүссэн эхний үлдэгдлийн зөрүүг санхүүгийн тайланд залруулах.

13. Анхаарал татахуйц чухал асуудлууд

"Карбин электрик интернэшнл" ХХК-д гэрээрээгээр ажил гүйцэтгэсэний замын санхүүжилтийн дутуу 160.0 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад хандсан байна.

14. МАТЕРИАЛЛАГ БУС ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР

2017 оны санхүүгийн тайланд бүртгэлийн буруу бичилтээс зардал өсгөсөн 6.0 сая төгрөг, үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийн зөрүү 9.1 сая, хуримтлагдсан элэгдэл 7.2 сая төгрөгийн нийт 22.3 сая төгрөгийн залруулаагүй материаллаг бус алдаа гарсныг залруулах зөвлөмж өгсөн.

15. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

МАКС санхүүгийн програмаар санхүүгийн тайлан гаргаж байгаа боловч бүрэн ашиглаагүй үндсэн хөрөнгө, цалинг Excel-ээр гаргасанаас үндсэн хөрөнгийн элэгдлийн 2016 оны эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн байсныг залруулаагүй тул тооцооллыг бүрэн шалгах шаардлагатай гэж үзлээ.

16. САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛИЙН НЭГТГЭЛ

“Орхон АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

“Орхон АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 265.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 237.0 сая төгрөгийн алдааг залруулж 28.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

17. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2016 онд “Найдвар-Од Аудит” ХХК санхүүгийн тайлангийн аудит хийж аудитаар 3 зөвлөмж өгсөнөөс 100% хэрэгжүүлсэн байна.

18. ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт


“Орхон АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 21 хуудас, хавсралтууд хуудас, байгууллагын санал ... хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК-ийн
ПАРТНЕР:
АХЛАХ АУДИТОР:
БЭЛТГЭСЭН: АУДИТОР:



М.СЭВЖИДМАА
С.СОДНОМЦЭРЭН
Д.ЧУЛУУНБАТ

“ОРХОН АЗЗА” ТӨХК 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК
Хаяг: УБ хот Чингэлтэй дүүрэг
4-р хороо Цэцээ гүн төв 206 тоот
Утас: 70001981, 99096584
Зөвлөх үйлчилгээ:
Утас: 19001981

Тэргүүлэх ач холбогдол № 1

Асуудал 1 Үндсэн хөрөнгө.....

Асуудал 4 Тайлант үеийн үр дүн

Тэргүүлэх ач холбогдол № 2

19. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын Олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

1. Үндсэн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

1. ТӨБЗГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А/5/3481 тушаалаар 15.2 сая төгрөгийн 10 төрлийн компьютер дагалдах хэрэгсэлийн хамт акталсан байна. Үүнд: 2014 онд ашиглалтанд орсон, 4 жил ашиглах хугацаатай, 1.9 сая төгрөгийн нэг бүрийн үнэтэй нийт 7.6 сая төгрөгийн 4 notebook, Epson L555 принтер 0.4 сая төгрөг, бүгд 8.0 сая төгрөгийн хөрөнгийг ашиглах хугацаа дуусаагүй байхад акталсан боловч албан хэрэгцээнд ашиглаж байна.

2. 2016 оны санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 7.2 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн үлдэгдэл 9.1 сая төгрөгөөр тус, тус илүү илэрхийлэгдсэн тухайн үед залруулга хийгээгүй байна.

Зөвлөмж

1. Акталсан боловч ашиглаж байгаа 8.0 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг орлогод авах.
2. Үндсэн хөрөнгө, хуримтлагдсан элэгдлийн 2016 онд үүссэн эхний үлдэгдлийн зөрүүг санхүүгийн тайланд залруулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ны дотор УАГ-т бичгээр ирүүлэх.

Эрсдэлүүд

Хөрөнгө алга болох, шамшигдах

Төсвийн захирагчийн хариу

Зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

1. Хуримтлагдсан үр дүн

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

Зөвлөмж

1. 2016 оны ТУЗ-ын гишүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг тайлагнаагүй 4.2 сая төгрөгийг нөхөж залруулахдаа тухайн тайлант жилийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар тайлагнаж зардлыг өсгөсөн нь Сангийн сайдын 249 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн "Нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулах", 15.2. "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" ..гэсэн заалтыг зөрчсөн


1. 2016 оны нийгмийн шимтгэл 4.2 сая төгрөгийг тухайн тайлант жилд зардлаар бүртгэж зардал өсгөснийг хуримтлагдсан үр дүнд залруулга хийж ААНОАТ-ыг нөхөж тооцох.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ны дотор УАГ-т бичгээр ирүүлэх.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

"СИ ЭС АЙ АУДИТ" ХХК-ИЙН
ПАРТНЕР:
АХЛАХ АУДИТОР:
БЭЛТГЭСЭН: АУДИТОР:



М.СЭВЖИДМАА
С.СОДНОМЦЭРЭН
Д.ЧУЛУУНБАТ

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөг/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | АУДИТ ХИЙГДСЭН | |
|-----------------|---|-------------------------|-------------------------|
| | | 2016 оны 12 сарын 31 | 2017 оны 12 сарын 31 |
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 260,230,443.35 | 297,372,416.84 |
| 1.1.2 | Дансны авлага | 38,364,314.00 | 344,407,065.00 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | | 13,856.38 |
| 1.1.4 | Бусад авлага | 246,350.10 | 71,000.00 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | 0.00 |
| 1.1.6 | Бараа материал | 266,565,018.96 | 381,458,420.83 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 565,406,126.41 | 1,023,322,759.05 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 474,131,181.77 | 323,676,163.13 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | | 880,000.00 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 474,131,181.77 | 324,556,163.13 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 1,039,537,308.18 | 1,347,878,922.18 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 7,459,450.02 | 78,900.01 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 268,856.00 | |
| 2.1.1.3 | Татварын өр | 114,233,980.82 | 177,278,343.24 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 4,396,660.47 | 0.00 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | | 235,159,982.00 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 126,358,947.31 | 412,517,225.25 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 626,893,956.00 | 626,893,856.00 |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 626,893,956.00 | 626,893,856.00 |

| | | | |
|--------|---------------------------------------|-------------------------|-------------------------|
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 753,252,903.31 | 1,039,411,081.25 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч: / Төрийн/ | 318,305,378.00 | 318,305,378.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 38,860,860.00 | 38,860,860.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (70,878,833.13) | (48,698,397.07) |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 286,287,404.87 | 308,467,840.93 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 1,039,540,308.18 | 1,347,878,922.18 |

19.3 АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | АУДИТЛАГДСАН | |
|---------------|---|-------------------------|-----------------------|
| | | 2016 оны 12 сарын 31 | 2017 оны 12 сарын 31 |
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 726,491,582.72 | 1,142,966,985.71 |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 665,000,000.00 | 893,346,128.00 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 61,491,582.72 | 249,620,857.71 |
| 4 | Түрээсийн орлого | - | 759,090.91 |
| 5 | Хүүний орлого | - | 2,849,064.86 |
| 8 | Бусад орлого | 49,620,423.02 | - |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 7,037,419.12 | 164,304,929.13 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 359,936,258.73 | 62,505,635.31 |
| 11 | Санхүүгийн зардал | - | 1,773,520.00 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (255,861,672.11) | 24,644,929.04 |
| 19 | Орлогын татварын зардал | - | 2,464,492.91 |
| 20 | Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | (255,861,672.11) | 22,180,436.13 |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (255,861,672.11) | 22,180,436.13 |
| 24 | Нийт дэлгэрэнгүй орлогын дүн | (255,861,672.11) | 22,180,436.13 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | | |

26

"Орхон АЗЗА" ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"Орхон АЗЗА" ТӨХК

(Аж ахуйн нэгжийн нэр)

2017 оны 12 сарын 31

/ төгрөг /


| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн ноон | Эзлийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|---|-----------------------|------------------|------------------------|-------------------------------------|-----------------------------------|---------------------------|------------------------|-----------------------|
| 1 | 2016 оны 12 сарын 31 | 318,305,378.00 | | | 38,860,860.0 | | | (70,878,833.13) | 247,426,544.87 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | | |
| 3 | Залруулсан үндэс | | | | | | | | |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | | | | |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | | |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | | | |
| 7 | Зарласан ногдол ашиг | | | | | | | | |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | | |
| 9 | 2016 оны 12 сарын 31 | 318,305,378.00 | | | 38,860,860.0 | | | (70,878,833.13) | 247,426,544.87 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | | |
| 11 | Залруулсан үндэс | | | | | | | | |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | | | | |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | | |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | | | |
| 15 | Зарласан ногдол ашиг | | | | | | | | |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | | |
| 17 | 2017 оны 12 сарын 31 | 318,305,378.00 | | | 38,860,860.0 | | | (48,698,397.00) | 308,467,841.00 |

ОШ ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛДҮГНЭЛТ

19.4 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | АУДИТ ХИЙГДСЭН | |
|---------------|--|-----------------------|----------------------|
| | | 2016 оны 12 сарын 31 | 2017 оны 12 сарын 31 |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 1,357,996,071.34 | 1,190,766,985.50 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 25,468,361.90 | 1,063,087,102.70 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | 2,849,064.90 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 1,332,527,709.44 | 124,830,817.90 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 1,061,145,484.06 | 1,123,486,060.65 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 184,125,199.00 | 219,589,073.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 124,807,138.20 | 94,443,881.00 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 435,159,195.56 | 647,282,732.65 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 4,280,294.12 | 14,527,029.50 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | - | 4,935,450.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 100,714,148.90 | 81,712,274.50 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 0.00 | 563,450.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 212,059,508.28 | 60,432,170.00 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 296,850,587.28 | 67,280,924.85 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 7,120,000.00 | 28,405,431.36 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 7,120,000.00 | 971,636.36 |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | 27,433,795.00 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (7,120,000.00) | (28,405,431.36) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 30,515,015.33 | 1,733,520.00 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 22,559,940.33 | - |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 7,955,075.00 | 1,733,520.00 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (30,515,015.33) | (1,733,520.00) |
| 4.1 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 259,215,571.95 | 37,141,973.49 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,014,871.40 | 260,230,443.35 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 260,230,443.35 | 297,372,416.84 |

АУДИТОР



Д.ЧУЛУУНБАТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудит хийгдсэн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

| Д/д | Үзүүлэлт | Х/Н | 2016 он | | 2017 он | | Харьцуулалт | |
|-----|---|-------|------------------|--------------------|--------------------|-------------|--------------------|--|
| | | | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | хувь | зөрүү | |
| 1 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт борлуулалт | | | | | | | |
| | A 1002 | М.ТӨГ | 95,444.7 | 93,407.6 | 157,200.0 | 1.68 | 63,792.40 | |
| | A 1001 | М.ТӨГ | 638,745.3 | 625,112.4 | 662,770.0 | 1.06 | 37,657.60 | |
| | Орон нутгийн чанартай зам засвар, барилгын ажил | М.ТӨГ | 41,921.8 | 451,290.0 | 326,605.1 | 0.72 | (124,684.90) | |
| | Үнийн дүн | М.ТӨГ | 776,111.8 | 1,169,810.0 | 1,146,575.1 | 0.98 | (23,234.90) | |
| | Нийт орлого | М.ТӨГ | 776,111.8 | 1,169,810.0 | 1,146,575.1 | 0.98 | (23,234.90) | |
| 2 | Үүнээс: Цэвэр борлуулалт | М.ТӨГ | 746,190.0 | 1,168,120.0 | 1,142,966.9 | 0.98 | (25,153.10) | |
| | Бусад орлого | М.ТӨГ | 29,921.8 | 1,690.0 | 3,608.2 | 2.14 | 1,918.20 | |
| | Нийт зардал | М.ТӨГ | 1,081,593.9 | 1,143,293.6 | 1,121,930.1 | 0.98 | (21,363.50) | |
| 3 | Үүнээс: Удирдлагын зардал | М.ТӨГ | 192,922.1 | 175,410.8 | 173,908.3 | 0.99 | (1,502.51) | |
| | Үйлдвэрлэлийн зардал | М.ТӨГ | 888,671.8 | 967,882.8 | 948,021.8 | 0.98 | (19,860.99) | |
| 4 | Татварын өмнөх ашиг | М.ТӨГ | (305,482.1) | 26,516.4 | 24,645.00 | 0.93 | (1,871.40) | |
| | Цэвэр ашиг /алдагдал/ | М.ТӨГ | (305,482.10) | 23,864.8 | 22,180.5 | 0.93 | (1,684.26) | |
| 5 | Төрийн захиргааны татвар | М.ТӨГ | 168,972.4 | 218,345.9 | 279,014.5 | 1.28 | 60,668.62 | |
| | Төрийн захиргааны татвар | М.ТӨГ | 0 | 2,651.6 | 2,464.5 | 0.93 | (187.10) | |
| 6 | Нийт зардал | М.ТӨГ | 77,611.18 | 116,981.0 | 114,657.5 | 0.98 | (2,323.49) | |

"Орхон АЗЗА" ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

| в / НДШ | М.ТӨГ | 39225.6 | 58,370.7 | 90,644.1 | 1.55 | 32,273.45 |
|---|-------|-----------|-----------|-------------|--------|--------------|
| г / Хүн амын орлогын татвар | М.ТӨГ | 42,410.40 | 31,159.80 | 63,396.4 | 2.03 | 32,236.60 |
| д / үл хөдлөх хөрөнгийн татвар | М.ТӨГ | 650.0 | 650.0 | 650.0 | 1.00 | - |
| е / Тээврийн хэрэгсэлийн татвар | М.ТӨГ | 1,138.7 | 983.3 | 1,164.0 | 1.18 | 180.70 |
| ё / бусад татвар | М.ТӨГ | 6,163.0 | 3,969.8 | 2710.9 | 0.68 | (1,258.90) |
| 7 Төрийн өмчийн ноогдол ашиг | М.ТӨГ | 1773.5 | 3,579.71 | 3,327.07 | 0.93 | (252.64) |
| 8 Нийт ажиллагсадын тоо | М.ТӨГ | 45 | 45 | 45 | 1.00 | - |
| 9 Нийт цалингийн сан | М.ТӨГ | 392,256.1 | 449,005.0 | 308,341.3 | 0.69 | (140,663.70) |
| 10 Нэг ажиллагчийн дундаж цалин | М.ТӨГ | 726.4 | 831.5 | 571.0 | 0.69 | (260.49) |
| 13 Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | М.ТӨГ | 1.39 | 0.98 | 0.98 | 1.00 | 0.00 |
| 14 Хөрөнгө оруулалт | М.ТӨГ | 15,416.8 | 58,495.0 | 1,761.6 | 0.03 | (56,733.40) |
| 15 Нийт авлага | М.ТӨГ | 38,610.6 | 11,200.0 | 1,230,329.0 | 109.85 | 1,219,129.00 |
| Үүнээс: Найдваргүй | М.ТӨГ | | | 0 | | - |
| Нийт өглөг | М.ТӨГ | 753,252.4 | 633,393.5 | 1,185,765.2 | 1.87 | 552,371.70 |
| 16 Өмчлөх хугацаат өр төлбөр | М.ТӨГ | 126,358.9 | 6,500.0 | 558,871.7 | 85.98 | 552,371.70 |
| Урт хугацаат өр төлбөр | М.ТӨГ | 626,893.5 | 626,893.5 | 626,893.5 | 1.00 | - |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ**

АУДИТОР Д.ЧУЛУУНБАТ